



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/92/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: П.Амаржаргал Утас: 88106992 Цахим хаяг: amarjargalp@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Contents

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	төгрөгөөр .. 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	төгрөгөөр .. 5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	төгрөгөөр.. 6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	төгрөгөөр.... 8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	төгрөгөөр .. 8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	төгрөгөөр .. 10
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Төлбөрийн акт	16
4.2 Албан шаардлага	16
4.3 Зөвлөмж.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

Алда. о. № _____ № 2/53

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D:\alban bichig\A4.docx

• 005020333

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains the Mongolian text "МОНГОЛЫН АУДИТ АГУУГА" (Mongolian Audit Agency) and "УЛСЫН АУДИТ АГУУГА" (State Audit Agency). The signature is written in a cursive style, crossing the stamp.

Б.МӨНХБАТ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>97,130,328.85</u>	<u>139,500,487.85</u>
33	АВЛАГА	5,633.00	24,627,792.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	5,633.00	2,327,792.00
335	Бусад авлага	00.00	22,300,000.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	22,300,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	97,124,695.85	114,872,695.85
351	Түүхий эд материал	2,662,300.00	7,071,700.00
35110	Тусгай зориулалттай материал	1,868,400.00	1,868,400.00
35130	Эм боох материал	793,900.00	5,203,300.00
354	Хангамжийн материал	94,462,395.85	107,800,995.85
35410	Бичиг хэргийн материал	2,089,200.00	4,678,000.00
35420	Аж ахуйн материал	91,591,595.85	100,064,475.85
35440	Түлш, шатах тослох материал	300,000.00	00.00
35460	Хүнсний материал	400,100.00	1,635,750.00
35470	Бусад хангамжийн материал	81,500.00	1,422,770.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,461,180,447.66</u>	<u>1,442,141,695.27</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	<u>1,461,180,447.66</u>	<u>1,442,141,695.27</u>
392	Биет хөрөнгө	<u>1,419,605,947.66</u>	<u>1,400,600,195.27</u>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,552,461,640.00	1,552,461,640.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-232,709,626.66	-255,235,669.48
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	177,306,108.93	192,987,828.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	-129,954,209.07	-137,197,225.59
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	99,183,221.96	103,111,221.96
39208	Хуримтлагдсан элэгдэл	-56,189,585.50	-65,035,998.55
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,000,000.00	3,000,000.00
39217	Ном	6,508,398.00	6,508,398.00
393	Биет бус хөрөнгө	<u>41,574,500.00</u>	<u>41,541,500.00</u>
39301	Программ хангамж	930,000.00	930,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-781,500.00	-814,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	41,426,000.00	41,426,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,558,310,776.51</u>	<u>1,581,642,183.12</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>7,762,395.00</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	<u>7,762,395.00</u>	<u>00.00</u>
413	Өглөг	<u>7,762,395.00</u>	<u>00.00</u>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	7,497,095.00	00.00
4136	Бусад өглөг	<u>265,300.00</u>	<u>00.00</u>
41361	Байгууллагад төлөх өглөг	265,300.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,550,548,381.51</u>	<u>1,581,642,183.12</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	<u>1,550,548,381.51</u>	<u>1,581,642,183.12</u>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	364,824,419.85	364,824,419.85
51101	Өмч: - төрийн	364,824,419.85	364,824,419.85
512	Хуримтлагдсан үр дүн	<u>467,958,645.24</u>	<u>499,052,446.85</u>
51210	Өмнөх үеийн үр дүн	467,958,645.24	467,958,645.24
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	31,093,801.61
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	717,765,316.42	717,765,316.42
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,558,310,776.51</u>	<u>1,581,642,183.12</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	898,715,853.51	850,258,114.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,379,861.51	338,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	6,379,861.51	338,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,379,861.51	338,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	817,252.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,562,609.51	00.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	00.00	338,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	145,154,492.00	155,258,414.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	747,181,500.00	694,661,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	747,181,500.00	694,661,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	51,140,792.00	57,737,987.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	49,089,892.00	37,550,080.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,050,900.00	20,187,907.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	94,013,700.00	97,520,427.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	94,013,700.00	97,520,427.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	938,815,687.11	819,164,312.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	938,815,687.11	819,164,312.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	807,069,750.11	760,596,825.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	541,947,881.00	529,084,711.00
210101	Үндсэн цалин	536,897,881.00	396,879,054.00
210102	Нэмэгдэл	5,050,000.00	93,931,644.00
210104	Урамшуулал	00.00	38,274,013.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,123,638.00	66,695,999.00
210201	Тэтгэврийн даатгал	46,065,570.00	32,347,850.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,419,479.00	34,348,149.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,335,583.00	00.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,027,547.00	00.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,275,459.00	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	93,123,294.00	97,306,427.00
210301	Гэрэл, цахилгаан	4,737,706.00	4,064,768.00
210302	Түлш, халаалт	88,385,588.00	93,241,659.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,178,980.08	5,794,186.00
210401	Бичиг хэрэг	4,045,820.00	2,498,400.00
210402	Тээвэр, шатахуун	4,168,730.08	1,693,350.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	376,380.00	165,886.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	49,800.00	220,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,538,250.00	1,002,550.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	214,000.00



Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2105	Нормативт зардал	18,531,940.00	5,831,150.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	122,700.00	441,600.00
210502	Хоол, хүнс	18,409,240.00	5,389,550.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,000.00	1,516,400.00
210604	Урсгал засвар	37,000.00	1,516,400.00
2107	Томилолт, зочны зардал	520,000.00	324,000.00
210702	Дотоод албан томилолт	520,000.00	324,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	861,500.00	13,123,230.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	411,500.00	12,473,230.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	500,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	150,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	74,745,517.03	40,920,722.39
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,406,100.00	2,209,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	520,000.00	63,250.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	71,819,417.03	38,648,472.39
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	131,745,937.00	58,567,487.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	49,083,933.00	51,824,930.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,657,630.00	16,913,880.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	36,006,303.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	31,101,050.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,420,000.00	3,810,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	15,134,489.00	2,251,207.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	2,251,207.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	67,527,515.00	4,491,350.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	67,527,515.00	4,491,350.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-40,099,833.60	31,093,801.61
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	21,964,837.62	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	21,964,837.62	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-21,964,837.62	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-62,064,671.22	31,093,801.61

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	892,335,992.00	849,920,114.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	892,335,992.00	849,920,114.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	747,181,500.00	694,661,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	747,181,500.00	694,661,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	51,140,792.00	57,737,987.00



Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	49,089,892.00	37,550,080.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,050,900.00	20,187,907.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	94,013,700.00	97,520,427.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	94,013,700.00	97,520,427.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	864,787,944.00	830,310,394.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	864,787,944.00	830,310,394.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	771,666,779.00	770,291,157.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	528,708,827.00	536,560,277.00
210101	Үндсэн цалин	384,467,954.96	404,354,620.00
210102	Нэмэгдэл	105,408,702.84	93,931,644.00
210104	Урамшуулал	38,832,169.20	38,274,013.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71,107,500.00	67,993,534.00
210201	Тэтгэврийн даатгал	50,149,200.00	48,477,244.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,475,900.00	4,878,343.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,039,500.00	3,899,326.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,095,200.00	973,912.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,347,700.00	9,764,709.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	93,423,294.00	97,520,427.00
210301	Гэрэл, цахилгаан	4,737,706.00	4,212,207.00
210302	Түлш, халаалт	88,685,588.00	93,308,220.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,929,900.00	9,734,339.00
210401	Бичиг хэрэг	1,425,800.00	3,639,200.00
210402	Тээвэр, шатахуун	2,200,000.00	1,693,350.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,142,880.00	1,686,949.00
210404	Ном, хэвлэл	371,320.00	839,820.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	49,800.00	220,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,740,100.00	1,655,020.00
2105	Нормативт зардал	20,723,555.00	11,527,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	983,700.00	837,500.00
210502	Хоол, хүнс	18,271,855.00	6,625,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,468,000.00	4,064,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,701,100.00	13,067,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	9,733,800.00
210604	Урсгал засвар	3,701,100.00	3,333,800.00
2107	Томилолт, зочны зардал	520,000.00	324,000.00
210702	Дотоод албан томилолт	520,000.00	324,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,367,803.00	26,544,730.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36,917,803.00	25,654,730.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	500,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	390,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,184,800.00	7,019,250.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	6,478,000.00

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,184,800.00	541,250.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	93,121,165.00	60,019,237.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,459,160.00	53,276,680.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	9,039,160.00	18,255,130.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	31,101,050.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,420,000.00	3,920,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	15,724,895.00	2,251,207.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	590,406.00	0.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	15,134,489.00	2,251,207.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	66,937,110.00	4,491,350.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	66,937,110.00	4,491,350.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	27,548,048.00	19,609,720.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	27,548,048.00	19,609,720.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	27,548,048.00	19,609,720.00
2200	Дотоод эх үүсвэрээр	27,548,048.00	19,609,720.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	27,548,048.00	19,609,720.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-27,548,048.00	-19,609,720.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	364,824,419.85	717,765,316.42	530,360,816.46	1,612,950,552.72
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	364,824,419.85	717,765,316.42	530,360,816.46	1,612,950,552.73
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-62,402,171.22	-62,402,171.22
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	364,824,419.85	717,765,316.42	467,958,645.24	1,550,548,381.51
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	364,824,419.85	717,765,316.42	467,958,645.24	1,550,548,381.51
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	364,824,419.85	717,765,316.42	467,958,645.24	1,550,548,381.51
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	31,093,801.61	31,093,801.61
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	364,824,419.85	717,765,316.42	499,052,446.85	1,581,642,183.12

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				



Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	793,996,700.00	787,690,777.00	6,305,923.00	99.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	793,996,700.00	787,690,777.00	6,305,923.00	99.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	770,128,200.00	765,515,147.00	4,613,053.00	99.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	537,676,200.00	536,395,277.00	1,280,923.00	99.76
210101	Үндсэн цалин	404,219,700.00	404,189,620.00	30,080.00	99.99
210102	Нэмэгдэл	94,171,700.00	93,931,644.00	240,056.00	99.75
210104	Урамшуулал	39,284,800.00	38,274,013.00	1,010,787.00	97.43
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгал төлөх шимтгэл	68,129,700.00	67,993,534.00	136,166.00	99.80
210201	Тэтгэврийн даатгал	48,553,500.00	48,477,244.00	76,256.00	99.84
210202	Тэтгэмжийн даатгал	4,894,000.00	4,878,343.00	15,657.00	99.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,915,200.00	3,899,326.00	15,874.00	99.59
210204	Ажилгүйдлийн даатгал	978,900.00	973,912.00	4,988.00	99.49
210205	Эрүүл мэндийн даатгал	9,788,100.00	9,764,709.00	23,391.00	99.76
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	99,335,000.00	97,520,427.00	1,814,573.00	98.17
210301	Гэрэл, цахилгаан	4,738,000.00	4,212,207.00	525,793.00	88.90
210302	Түлш, халаалт	94,393,000.00	93,308,220.00	1,084,780.00	98.85
210303	Цэвэр, бохир ус	204,000.00	00.00	204,000.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,244,400.00	9,567,339.00	677,061.00	93.39
210401	Бичиг хэрэг	3,848,600.00	3,642,200.00	206,400.00	94.64
210402	Тээвэр, шатахуун	1,700,000.00	1,693,350.00	6,650.00	99.61
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,711,000.00	1,686,949.00	24,051.00	98.59
210404	Ном, хэвлэл	891,500.00	839,820.00	51,680.00	94.20
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	540,000.00	220,000.00	320,000.00	40.74
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,553,300.00	1,485,020.00	68,280.00	95.60
2105	Нормативт зардал	11,684,800.00	11,527,000.00	157,800.00	98.65
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	851,600.00	837,500.00	14,100.00	98.34
210502	Хоол, хүнс	6,664,300.00	6,625,200.00	39,100.00	99.41
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,168,900.00	4,064,300.00	104,600.00	97.49
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,419,700.00	26,990,520.00	429,180.00	98.43
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,000,000.00	19,728,720.00	271,280.00	98.64
210602	Тавилга	4,000,000.00	3,928,000.00	72,000.00	98.20
210604	Урсгал засвар	3,419,700.00	3,333,800.00	85,900.00	97.49
2107	Томилолт, зочны зардал	379,700.00	324,000.00	55,700.00	85.33
210702	Дотоод албан томилолт	379,700.00	324,000.00	55,700.00	85.33
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,327,700.00	2,324,000.00	3,700.00	99.84
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,377,700.00	1,269,000.00	108,700.00	92.11
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	608,700.00	-108,700.00	121.74
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	446,300.00	3,700.00	99.18



Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12931000.00	12873050.00	57,950.00	99.55
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,000,000.00	7,978,000.00	22,000.00	99.73
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,931,000.00	4,895,050.00	35,950.00	99.27
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23868500.00	22175630.00	1,692,870.00	92.91
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,868,500.00	22,175,630.00	1,692,870.00	92.91
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	19,926,700.00	18,255,130.00	1,671,570.00	91.61
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,941,800.00	3,920,500.00	21,300.00	99.46
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	793,996,700.00	787,690,777.00	6,305,923.00	99.21
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	694,661,700.00	690,170,350.00	4,491,350.00	99.35
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	694,661,700.00	690,170,350.00	4,491,350.00	99.35
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	99,335,000.00	97,520,427.00	1,814,573.00	98.17
132001	Орон нутгийн төсвөөс	99,335,000.00	97,520,427.00	1,814,573.00	98.17
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	45.00	45.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	33.00	33.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	11.00	11.00	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, гүүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	51,140,792.00	57,737,987.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	51,140,792.00	57,737,987.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	51,140,792.00	5,053,418.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	51,140,792.00	5,053,418.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	51,140,792.00	5,053,418.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,140,792.00	37,550,080.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	51,140,792.00	37,550,080.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	6,449,030.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	31,101,050.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	15,134,489.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	51,140,792.00	57,737,987.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	51,140,792.00	57,737,987.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	49,089,892.00	52,684,569.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,050,900.00	5,053,418.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 84 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Санхүүгийн тайлант хугацаанд сургуулийн захирал С.Дагвадорж 2021.07.20-ныг хүртэл, Г.Пүрэвцагаан нь 2021 оны 07 дугаар сарын 21-нээс эхлэн нэгдүгээр гарын үсгийг, нягтлан бодогч М.Мягмарсүрэн нь 2021.04.30-ныг хүртэл, Ж.Оюунтуяа нь 2021 05 дугаар сарын 01-нээс эхлэн хоёрдугаар гарын үсгийг тус тус зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Байгууллагын зорилго нь “Хүний хөгжлийг хангахуйц төрийн үйлчилгээний орчин сайжруулж боловсролын үйлчилгээний чанар, үр өгөөжийг дээшлүүлэн, стандарт, хангалтыг дээшлүүлэх, Боловсролын үйлчилгээний орчин сайжруулах, Багш удирдах ажилтны ур чадварыг дээшлүүлэх, Сургалтын стандарт хангалтыг аймгийн дунджаас дээгүүр байлгаж элсэлтийн ерөнхий шалгалтын оноо улсын дунджаас дээгүүр оноо авч аймгийн хэмжээнд эхний гуравт жагсах” гэсэн эрхэм зорилгын доор үйл ажиллагаагаа явуулсан байна.

- Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорилт гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын 2021 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн А/37 тоот тушаалаар батлагдсан салбарын хэмжээнд мөрдөж байгууллагын өөрийн онцлогт нийцүүлэн боловсруулж холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг ашиглаж байна.

Тус байгууллага нь дотоод аудитын албан байхгүй бөгөөд дотоод аудитын чиг үүргийг аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь хэрэгжүүлдэг ба Эрдэнэцогт сумын



Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатны материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 938,815.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 9,388.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 6,571.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 8,191.6 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 1,581,642.1 мянган төгрөг болж өмнөх оноос 23,331.4 мянган төгрөгөөр буюу 1.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	98,130.30	137,977.10	39,846.80
Мөнгөн хөрөнгө	-	-	0.00
Авлага	0.05	24,627.70	24,627.65
Урьдчилгаа	-	-	0.00
Бараа материал	97,124.60	114,872.60	17,748.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,461,180.40	1,442,141.60	-19,038.80
Үндсэн хөрөнгө	1,880,815.30	1,900,425.00	19,609.70
Хуримтлагдсан элэгдэл	-419,634.90	458,283.30	877,918.20
Нийт хөрөнгө	1,558,310.70	1,581,642.10	23,331.40
Өр төлбөр	7,762.30	0	-7,762.30
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,550,548.30	1,581,642.10	31,093.80
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,558,310.70	1,581,642.10	23,331.40



Бараа материалын дансны үлдэгдэл 114,872.6 мянган төгрөг болж 17,748.0 мянган төгрөгөөр өссөн нь аж, ахуй материалын үлдэгдэл өмнөх оноос 8,472.8 мянган төгрөг, бичиг хэргийн материалын үлдэгдэл 2,588.8 мянга, эм боох материалын үлдэгдэл 4,409.4 мянга, хүнсний материалын үлдэгдэл 1,235.6 мянга, бусад хангамжийн материалын үлдэгдэл 1,341.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн ба БСУГ-аас 248.0 мянган төгрөгийн тусгаарлах байрны багц, аймгийн ЗДТГ-аас 90.0 мянган төгрөгийн ариутгалын бодис тус тус хүлээн авч орлогоор бүртгэсэн нь бараа материал голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,900,425.0 мянган төгрөг болж 19,609.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 15,681.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 3,928.0 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл худалдан авч Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 271-р тогтоолын 4.1.1-д заасны дагуу холбогдох дансанд орлогоор бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,579,549.5 мянган төгрөг болж 29,001.2 мянган төгрөгөөр нэмэгдэж тайлант үеийн үр дүн 29,001.2 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, зарлагыг 888,043.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 107,949.8 мянган төгрөгөөр бууруулж 780,094.1 мянган төгрөгөөр анх батлагдсан ба 2021 оны 12 дугаар сард төсөвт зохицуулалт хийгдэж 793,996.7 мянган төгрөг болж 13,902.6 мянган төгрөг буюу 1.7 хувиар нэмэгдүүлж батлагдсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 793,996.7 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 787,690.7 мянга, орон нутгийн төсвөөс 6,305.9 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 694,661.7 мянга, орон нутгийн төсвөөс 99,335.0 мянга нийт 793,996.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 787,690.7 мянган төгрөгийг зарцуулж 6,305.9 мянган төгрөг буюу 0.8 хувийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Харин орон нутгийн төсвийн санхүүжилтийг 1,814.5 мянган төгрөгөөр батлагдсан төлөвлөгөөнөөс дутуу санхүүжүүлсэн байгаа нь төсвийг гүйцэтгэлтэй нь уялдуулан олгосонтой холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 787,690.7 мянган төгрөг буюу 99.2 хувьтай байгаа нь цалингийн зардал 1,280.9 мянга, норматив зардал 157.8 мянга, хангамжийн материалын зардал 677,1 мянга, эд хогшил урсгал засварын зардал 429.2 мянга, томилолтын зардал 55,7 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 1,814.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн Төрийн сан банкин дахь 100032015404 тоот дансанд хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад олгох тэтгэмж, урамшууллын зардалд 31,101.1 мянга, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 6,449.0 мянга, Өмнөх оны санхүүжилтийн авлага 15,134.4, түрээсийн сурах бичгийн номын орлого 1,394.5 мянга, постын хоолны махны үнэ 540.0 мянга, тусгаарлах байрны хоолны үнэ 1,126.0 мянга, акталсан цонх, банзны үнэ 1,040.0 мянга, шалгалтын бичиг хэргийн зардалд 245.3 мянга, санхүүжилт 688.0 мянга, ШШГГ-аас төлбөр 20.0 мянга нийт 57,737.9 мянган төгрөгийг олгосныг хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад олгох тэтгэмж, урамшууллын зардалд 31,101.1 мянга, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 6,449.0 мянга, гал тогооны тоног төхөөрөмж 13,000.0 мянга, түрээсийн сурах бичгийн төлбөрт 2,047.7 мянга, постны махны зардалд 1,852.5 мянга, бэлэг дурсгал шагналын зардалд 1,036.5 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд Ковид-19 цар тахалтай холбоотой сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа БШУЯ, улсын болон аймгийн онцгой комиссоос өгсөн шийдвэр, чиглэлийн дагуу тусгай горимоор хичээллэсэн.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор Б.Нарангэрэл санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 44 арга хэмжээг төлөвлөж хэрэгжилт 95%-тай гэж тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 819,164.3 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 119,651.3 мянган төгрөгөөр буюу 14.6 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь хангамжийн материал өмнөх оноос буурсан бол бусад зардлууд нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд Шилэн дансны нэгдсэн системд нийт 1,156,781.8 мянган төгрөгийн 151 мэдээлэл байршуулахаас хугацаа болоогүй 2 мэдээлэл, мэдээлбэл зохих 149 мэдээллээс 78,756.7 мянган төгрөгийн 20 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	6	3	2
2	Хагас жил	4	4	2	2	0
3	Улирал бүр	1	4	1	3	0
4	Сар бүр	3	36	32	4	0
5	Тухай бүр	8	96	88	8	0
	Нийт	27	151	129	20	2

3.9.2 Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 694,661.7 мянга, орон нутгийн төсвөөс 99,335.0 мянга нийт 793,996.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 787,690.7 мянган төгрөгийг зарцуулж 6,305.9 мянган төгрөг буюу 0.8 хувийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Харин орон нутгийн төсвийн санхүүжилтийг 1,814.5 мянган төгрөгөөр батлагдсан төлөвлөгөөнөөс дутуу санхүүжүүлсэн байгаа нь төсвийг гүйцэтгэлтэй нь уялдуулан олгосонтой холбоотой байна.

Тайлант онд тогтмол зардалд 99,335.0 мянган төгрөг батлагдсан ба нийт батлагдсан төсвийн 20 хувь нь 19,867.0 мянган төгрөг байна. Тус онд 1,814.5 мянган төгрөгийн хэмнэлт үүссэн бөгөөд 18,052.5 мянган төгрөгийн хэмнэлт үүсгээгүй байгаа нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын “1.8. байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах” гэсэн заалттай бүрэн нийцэхгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 21,412.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч 626.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах 1 албан шаардлага өгч, зөрчлийг давтан гаргахгүй байх 5 заалт бүхий зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажиллаж хэрэгжилтийн тайланг 2021 оны 06 дүгээр сарын 17-ны өдрийн 53 тоот албан бичгээр ирүүлсэн ба зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах аяны хүрээнд шалгасан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар 175,909.3 мянган төгрөгийн 9 зөрчил илэрснээс 27,383.4 мянган төгрөгийн санхүүгийн тайлангийн аудитын, 148,525.8 мянган төгрөгийн нийцлийн аудитын алдаа зөрчил илэрснээс 1,036.5 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 174,872.8 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 8 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлээ.

4.1 Төлбөрийн акт

4.1.1 Нэмэлт санхүүжилт дансанд акталсан хөрөнгийн орлого 1,040.0 төгрөгийг төвлөрүүлж зөвшөөрөлгүй 1,036.5 төгрөгийг бэлэг дурсгалын зүйлд зарцуулсан байна.

Энэ нь Энэ нь төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.2.төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх", 46 дугаар зүйлийн 46.4.Энэ хуулийн 46.3.2, 46.3.3-т заасан урамшууллыг хуваарилах асуудлыг байгууллагын нийт ажилтныг оролцуулсан хамт олны хурлаар хэлэлцэн, шийдвэрлэх бөгөөд хамт олны хурлын тэмдэглэл болон шийдвэрийг үндэслэн тухайн шатны төрийн сан зарцуулах эрх олгоно", Сангийн сайдын 2019 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 74 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Хууль журам зөрчиж төсвөөс зарцуулсан 1.036.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоов.

4.2 Албан шаардлага

4.2.1 Нийгмийн даатгалд 5 албан хаагчийн цалин 10,279.4 мянган төгрөгийн илүү, 8 албан хаагчийн цалинг 3,900.6 мянган төгрөгөөр дутуу мэдээлж мэдээлж нийгмийн даатгалд 1,524,3 мянган төгрөгийг илүү төлсөн байна.

Энэ нь Нийгмийн даатгалыг тухай хуулийн 16 дугаар зүйлийн "1 Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн болон ажил олгогчийн тухайн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын төрөл бүрээр энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр сар бүр тооцож, тухайн сард нь багтаан нийгмийн даатгалын сангийн дансанд шилжүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Нийгмийн даатгалд 5 албан хаагчийн цалин 10,279.4 мянган төгрөгийн илүү, 8 албан хаагчийн цалинг 3,900.6 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн цалинг залруулан мэдээлж төсвөөс төлсөн шимтгэлийн мөнгийг орон нутгийн орлогод төвлөрүүлэх албан шаардлага өгөх.

4.3 Зөвлөмж

4.3.1 Тайлант онд 1,749.9 мянган төгрөгийг эм бэлдмэл, тестийг эмчийн жор болон үзлэгийн бүртгэлгүй зарцуулсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Цаашид холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллаж анхан шатны баримтад тулгуурлан ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгаж байх зөвлөмж өгөв.

4.3.2 Анхан шатны баримтын дутуу, анхан шатны баримтгүй 12,303.7 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Цаашид холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллаж анхан шатны баримтад тулгуурлан ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгаж байх зөвлөмж өгөв.

4.3.4 Үдийн цайны зардлаас 1,422.8 мянга, хоол хүнсний зардлаас 1,635.7 мянган төгрөгийн хүнсний материал нөөц бүрдүүлсэн.

Энэ нь Энэ нь Төсвийн тухай хуулийн Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолын 4-т "Нэг хүүхдэд ногдох дундаж нормативаар санхүүжүүлэх зардлын гүйцэтгэлийг хүүхэд өдрөөр хянаж зөрүүг тооцож байх" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Цаашид төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зардлын гүйцэтгэлийг хүүхэд өдрөөр хянаж зөрүүг тооцож байх зөвлөмж өгөв.

4.3.5 Тооллогын комисс тусгай зориулалтын материал 1,868.4 мянга, бусад үндсэн хөрөнгө 3,000.0 мянган төгрөгийн үндсэн болон эргэлтийн хөрөнгийг тоолгод хамруулсан бүртгэл байхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 12 дугаар зүйлийн 12.2.Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн: Цаашид холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж хөрөнгийн тооллогыг чанартай бүрэн хийж гүйцэтгэж байх зөвлөмж өгөв.

4.3.6 Тогтмол болон бараа үйлчилгээний бусад зардлаас 1,046.1 мянган төгрөгийг цалингийн зардалд гүйлгэн батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5. батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; гэсэн заалтыг зөрчин байна.

Шийдвэрлэсэн: Цаашид холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллаж батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах зөвлөмж өгөв.

4.3.7 Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл мэдээлбэл зохих 149 мэдээллээс тухай бүр оруулахаас 78,756.7 мянган төгрөгийн мэдээлэл хугацаа хоцроож, 51,716.6 мянган төгрөгийн мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл ..6.4.4, 6.4.5, 6.4.6.. дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Хуулийн цаглаварт хугацаанд мэдээллийг бүрэн, хугацаанд нь үнэн зөв мэдээлж байх, удирдлагаас түүнд тавих хяналтыг сайжруулах зөвлөмж өгөх.

4.3.8 Тайлант онд тогтмол зардалд 99,335.0 мянган төгрөг батлагдсан ба нийт батлагдсан төсвийн 20 хувь нь 19,867.0 мянган төгрөг байна. Тус онд 1,814.5 мянган төгрөгийн хэмнэлт үүссэн бөгөөд 18,052.5 мянган төгрөгийн хэмнэлт үүсгээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын “1.8. байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах” гэсэн заалттай бүрэн нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Цаашид дээд шатны байгууллагаас гаргасан тушаал шийдвэрийг мөрдөн хэрэгжүүлэх талаар тодорхой ажил зохион байгуулж ажиллах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
А	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Эрдэнэцогт сумын ЕБС	1	27,383.5	0	0	1	1,036.4	1	6,378.8	5	19,968.2
	Дүн										
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	Эрдэнэцогт сумын ЕБС	2	148,525.8	0	0	0	0	0	0	2	148,525.8
	Дүн										
	НИЙТ ДҮН	3	175,909.3	0	0	1	1,036.4	1	6,378.8	7	168,493.3

_____ оОо _____